

# АЛБАН ХААГЧДААС АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮНГИЙН ТУХАЙ

## ИЛТГЭХ ХУУДАС

2018.10.31

Улаанбаатар хот

НҮГ-ын ажилтан, албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 29-ний өдрийн хугацаанд хаалттай 10, нээлттэй 1 асуултын хүрээнд авлаа. Судалгаанд 218 буюу нийт ажилтан, албан хаагчийн 83,5% нь хамрагдлаа.

1. Байгууллагын удирдлагын зүгээс явуулж буй үйл ажиллагаанд ажилтан, албан хаагчдын хүлээлтэд нийцдэг эсэх талаар:



Дээрхи графикаас харахад судалгаанд оролцогчдоос 90 ажилтан, албан хаагч буюу 41% нь “5” гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд хамгийн цөөн 12 ажилтан, албан хаагч буюу 6% нь “2” гэсэн үнэлгээ өгсөн байна.


2. Байгууллагын үйл ажиллагааны талаар ажилтан албан хаагчдад хангалттай мэдээлэл өгдөг эсэх талаар:



Дээрхи графикаас харахад судалгаанд оролцогчдоос 99 ажилтан, албан хаагч буюу 45% нь “5” гэсэн үнэлгээ өгсөн байна. Харин 8 ажилтан, албан хаагч буюу 4% нь “2” гэсэн үнэлгээ өгсөн.

3. Шууд удирдлага ажлаа бүрэн дүүрэн хийж чадаж байгаа эсэх талаар:


**Таны шууд удирдлага ажлаа бүрэн дүүрэн хийж чадаж байна уу гэсэн асуултад өгсөн үнэлгээ**



Графикаас харахад судалгаанд оролцогчдоос 184 ажилтан, албан хаагч буюу 85% нь “Сайн”, 27 ажилтан, албан хаагч буюу 12% нь “Дунд”, 7 ажилтан, албан хаагч буюу 3% нь “Хангалтгүй” үнэлгээ тус тус өгсөн байна.

4. Байгууллагын удирдлагын зүгээс харилцааны хувьд ил тод, ойлгомжтой талаар:


**Байгууллагын удирдлагын зүгээс харилцааны хувьд ил тод, ойлгомжтой байдаг эсэх**



Графикаас харахад судалгаанд оролцогчдоос 152 ажилтан, албан хаагч буюу 70% нь “Сайн”, 49 ажилтан, албан хаагч буюу 22% нь “Дунд”, 17 ажилтан, албан хаагч буюу 8% нь “Хангалтгүй” үнэлгээ тус тус өгсөн байна.

5. Удирдлагууд танд тулгарсан аливаа асуудлыг нээлттэй, түргэн шуурхай шийдвэрлэдэг эсэх талаар:

**Удирдлагууд танд тулгарсан аливаа асуудлыг нээлттэй бөгөөд түргэн шуурхай шийдвэрлэж чаддаг эсэхэд өгсөн үнэлгээ**



Дээрх графикаас харахад судалгаанд оролцогчдоос 186 ажилтан, албан хаагч буюу 85% нь “Тийм” гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд 32 ажилтан, албан хаагч буюу 15% нь “Үгүй” гэж үзсэн байна.

6. Мэдээ мэдээллийн цагт сэтгэл ханамжтай байдаг эсэх талаар:



Дээрх графикаас харахад судалгаанд оролцогчдоос 180 ажилтан, албан хаагч буюу 82% нь “Сайн”, 34 ажилтан, албан хаагч буюу 16% нь “Дунд”, 4 ажилтан, албан хаагч буюу 2% нь “Хангалтгүй” гэсэн үнэлгээ өгсөн байна.

7. Хамтран ажиллагсадын талаар:



Дээрх графикаас харахад ажилтан, албан хаагчдаас 213 нь таалагддаг, 5 нь таалагддаггүй гэсэн үнэлгээ өгсөн байна.

8. Ажилтан, албан хаагчид ажлын байрныхаа орчин, нөхцөлд сэтгэл хангалуун эсэх талаар:



Дээрх графикаас харахад 178 ажилтан, албан хаагч “Сайн”, 34 ажилтан, албан хаагч “Дунд”, 6 ажилтан, албан хаагч “Хангалтгүй” гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна.

9. Албан ажлаа хийхэд шаардагдах багаж хэрэгсэл, материалаар бүрэн хангагдаж байгаа эсэх талаар:




Дээрх графикаас харахад судалгаанд оролцогчдын 171 нь тийм, 47 нь үгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.

10. Ажилтан, албан хаагчид ажил үүрэг гүйцэтгэх явцад гарч буй асуудлын талаар:

Тус асуултанд судалгаанд оролцосон 218 ажилтан, албан хаагчаас 26 нь хариулж бичсэн бөгөөд хариулсан байдлыг графикаар харуулбал:

### Ажил үүргээ гүйцэтгэх явцад тулгарч буй асуудал



#### Дүгнэлт:

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, зохион байгуулж байгаа ажил, түүний хүртээмжийн талаар сэтгэл ханамжийн судалгааг авахад нийт ажилтан, албан хаагчдын 83,5% буюу 218 ажилтан, албан хаагч хамрагдсан. Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, мэдээ мэдээллийн хүртээмж, удирдлагын харилцааны ёс суртахуун, ажилтан, албан хаагчдад тулрагч буй асуудлыг түргэн шуурхай шийддэг байдал, хамтран ажиллагсад болон ажлын орчин, нөхцлийн талаарх санал асуулгад дийлэнхи нь эерэг үнэлгээ өгсөн байна. Гэвч цөөн тооны ажилтан, албан хаагчдаас тулгамдаж буй асуудлуудын талаар дараах санал, хүсэлт гаргасан.

- Ажлын ачаалал их байгаа хэсэгт ажлыг зөв зохион байгуулах,

- Хөдөлмөр хамгааллын хувцасны материалыг сайжруулах талаар анхаарах,
- Илгэн алчуурыг улирал тутам олгох талаар судлах,
- Цэвэрлэгээний бодисын чанарыг сайжруулах талаар судлах,

Дээрхи санал, хүсэлтийг захиргааны зүгээс хүлээн авч цаашид анхааран ажиллах болно.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ